

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2026 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



**УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР**

2026 ОНЫ 05 ДУГААР САРЫН 13-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

**ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРОО**

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ГАЗАР

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2026 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА

2026 оны 05 дугаар сарын 13-ны өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2 – 7
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	8 – 40
<hr/>	
1. <i>Байнгын хорооны тогтоолын төсөл /Ерөнхий хяналтын сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай/</i>	15 – 20
<hr/>	
2. <i>Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж нарын 5 гишүүн 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	20 – 27
<hr/>	
3. <i>“Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Б.Пунсалмаа нарын 13 гишүүн 2026.05.07-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	27 – 40
<hr/>	

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
Төсвийн байнгын хорооны 05 дугаар сарын 13-ны өдөр
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Н.Наранбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 30 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 56.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 52 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

*Томилолттой: Т.Аубакир, Ц.Даваасүрэн, Л.Мөнхбаясгалан,
П.Мөнхтулга, Д.Энхтүвшин;
Чөлөөтэй П.Ганзориг, Г.Тэмүүлэн;
Эмнэлгийн чөлөөтэй: Ж.Ганбаатар, Б.Мөнхсоёл, Д.Үүрийнтуяа;
Тасалсан: Д.Пүрэвдаваа.*

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар, П.Сайнзориг, С.Лодойсамбуу, Ж.Золжаргал нар санал хэлэв.

Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх, Дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай асуудлыг хойшлуулах гэсэн горимын санал гаргав.

Н.Наранбаатар: Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатарын гаргасан, Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг хойшлуулах гэсэн горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 8
Бүгд: 18

55.6 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 61.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Н.Наранбаатар: Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатарын гаргасан, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг хойшлуулах гэсэн горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 7

Бүгд: 18

61.1 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Н.Наранбаатар: Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатарын гаргасан, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг хойшлуулах гэсэн горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 8

Бүгд: 18

55.6 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Н.Наранбаатар: Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатарын гаргасан, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг хойшлуулах гэсэн горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 6

Бүгд: 18

66.7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Н.Наранбаатар: Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатарын гаргасан, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг хойшлуулах гэсэн горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 11

Бүгд: 18

38.9 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Н.Наранбаатар: Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатарын гаргасан, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг хойшлуулах гэсэн горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 4
Бүгд: 18
77.8 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг “Ерөнхий хяналтын сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай”, “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг хойшлуулах гэсэн горимын санал гаргав.

Н.Наранбаатар: Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн гаргасан, “Ерөнхий хяналтын сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг хойшлуулах гэсэн горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 11
Бүгд: 18
38.9 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Н.Наранбаатар: Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн гаргасан, “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг хойшлуулах гэсэн горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 12
Бүгд: 18
33.3 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Н.Наранбаатар: Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатарын гаргасан, Дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай асуудлыг хойшлуулах гэсэн горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 8
Бүгд: 18
55.6 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ерөнхий хяналтын сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Ё.Энхсайхан, Бат.Баярмаа, референт Г.Нарантуяа, С.Тэгшжаргал нар байлцав.

Байнгын хорооны дарга Н.Наранбаатар Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Байнгын хорооны тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргал санал хэлэв.

Н.Наранбаатар: “Ерөнхий хяналтын сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 10
Бүгд: 18
44.4 хувийн саналаар тогтоолын төсөл дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг, Ж.Батжаргал, Г.Ганбаатар нар үг хэлэв.

Уг асуудлыг 15 цаг 23 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж нарын 5 гишүүн 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Ё.Энхсайхан, Бат.Баярмаа, референт Г.Нарантуяа, С.Тэгшжаргал нар байлцав.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг, Б.Пүрэвдорж нар үг хэлж, Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам тайлбар хийв.

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Ж.Батжаргал ажлын 4 өдрийн завсарлага авах тухай мэдэгдэж, уг асуудлаар завсарлага авав. /15:51/

Гурав. “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Б.Пунсалмаа нарын 13 гишүүн 2026.05.07-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, “Барилгын хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Д.Мөнхбаатар, мөн газрын ерөнхий инженер З.Энх-Оргил, “Барилгын хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын Барилга, байгууламжийн зураг төслийн магадлал, зохион байгуулах хэлтсийн дарга Г.Мөнхболд, “Зам, тээврийн хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын Бодлогын хэрэгжилт, зураг төслийн магадлал, стандарт, норм, нормативын хэлтсийн дарга Э.Балт, мөн газрын ерөнхий инженер Я.Өнөртүвшин, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын шинжээч Т.Хонгор, Улсын Их Хурлын гишүүний зөвлөх Б.Нэргүй, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн ажлын албаны зөвлөх Д.Амарбаясгалан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Ё.Энхсайхан, Бат.Баярмаа, референт Г.Нарантуяа, С.Тэгшжаргал нар байлцав.

Төсөл санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Б.Пунсалмаа танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа, Да.Цогтбаатар нарын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Пунсалмаа, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг, Д.Батбаяр, Г.Ганбаатар нар үг хэлэв.

Н.Наранбаатар: “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 5
Бүгд: 19
73.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төсвийн байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 16 цаг 22 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 31 минут үргэлжилж, 30 гишүүнээс 19 гишүүн хүрэлцэн ирж, 63.3 хувийн ирцтэйгээр 16 цаг 23 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Н.НАРАНБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ГАЗРЫН
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 оны 05 дугаар сарын 13-ны өдөр, Лхагва гараг
Төрийн ордны “ИХ ЭЗЭН ЧИНГИС ХААН” танхим
14 цаг 52 минут

ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Н.Наранбаатар: Эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Байнгын хорооны гишүүдийн олонх нь хүрэлцэн ирж, ирц 56.7 хувьтай бүрдсэн тул Төсвийн байнгын хорооны 2026 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. /алх цохив/

Гишүүд танхимдаа орж ирээрэй. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7.8-д заасны дагуу хуралдааны ирцийг гишүүний нэрээр нь танилцуулна.

Норовын Алтанхуяг, Ринчиндоржийн Батболд, Хөххүүгийн Болормаа, Хассуурийн Ганхуяг, Нанзадын Наранбаатар, Даваагийн Цогтбаатар, Мягмарсүрэнгийн Бадамсүрэн, Жигжидийн Батжаргал, Хүрэлбаатарын Булгантуяа, Дамдинсүрэнгийн Жаргалсайхан, Пүрэвжавын Сайнзориг, Баттогтохын Чойжилсүрэн, Далайн Батбаяр, Жамбын Батсуурь, Гомбын Ганбаатар, Батжаргалын Заяабал, Банзрагчийн Түвшин нарын гишүүд хуралдаанд ирсэн байна.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Гишүүд орж ирээрэй, ирцэд орсон гишүүд орж ирээрэй. Санал хураалттай байгаа тул ирцэд орсон гишүүд “Их эзэн Чингис хаан” танхимд орж ирье.

Хэлэлцэх асуудлаа танилцуулъя.

- **Нэгдүгээрт,** Дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай асуудал.
- **Хоёрдугаарт,** Байнгын хорооны тогтоолын төсөл. Ерөнхий хяналтын сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай.
- **Гуравдугаарт,** Байнгын хорооны тогтоолын төсөл. Ажлын хэсэг байгуулах тухай.
- **Дөрөвдүгээрт,** Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд.

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 05 дугаар сарын 07-ны өдөр өргөн мэдүүлсэн. Хэлэлцэх эсэх.

- **Тавдугаарт**, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл. Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 05 дугаар сарын 07-ны өдөр өргөн мэдүүлсэн. Хэлэлцэх эсэх.
- **Зургадугаарт**, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд. Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 05 дугаар сарын 07-ны өдөр өргөн мэдүүлсэн. Хэлэлцэх эсэх.
- **Долдугаарт**, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд. Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 05 дугаар сарын 07-ны өдөр өргөн мэдүүлсэн. Хэлэлцэх эсэх.
- **Наймдугаарт**, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл. Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж нарын 5 гишүүн 2025 оны 06 дугаар сарын 09-ний өдөр өргөн мэдүүлсэн. Хэлэлцэх эсэх.
- **Есдүгээрт**, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл. Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа нарын 32 гишүүн 2026 оны 03 дугаар сарын 30-ны өдөр өргөн мэдүүлсэн. Хэлэлцэх эсэх.
- **Аравдугаарт**, “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл. Улсын Их Хурлын гишүүн Х.Пунсалмаа нарын 13 гишүүн 2026 оны 05 дугаар сарын 07-ны өдөр өргөн мэдүүлсэн. Хэлэлцэх эсэх.

Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүн байна уу? Да.Цогтбаатар гишүүн саналаа хэлье.

Да.Цогтбаатар: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе.

Засгийн газраас өргөн мэдүүлсэн Татварын хуулиудтай холбоотой асуудлууд дээр Ардчилсан намын бүлэг дээр асуудлуудыг нь хэлэлцэж ярилцах асуудлууд байгаа. Танилцуулгууд нь хийгдээгүй байгаа.

Ийм учраас татвартай холбоотой Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Хувь хүний орлогын

албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл Б.Пүрэвдорж нарын 5 гишүүнээс өргөн мэдүүлсэн.

Тэгээд Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл Ж.Баярмаа нарын гишүүдээс өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хойшлуулах санал гаргаж байна.

Н.Наранбаатар: Өөр.? П.Сайнзориг гишүүн санал гаргана.

П.Сайнзориг: Байнгын хорооны гишүүддээ өдрийн мэнд хүргэе.

Да.Цогтбаатар дарга энэ татварын хуулиудыг яалаа. Бид нарт яг шууд өнөөдөр гар дээр тавьж байгаа нэг материал байна лээ. Нэг ажлын хэсэг. Тов тогтоох асуудалтай холбоотой.

Энэ дээр ч гэсэн танилцах хэрэгтэй байна. Бүлгүүдээс нэр ирсэн юм уу, үгүй юм уу гэдгийг тодруулмаар байгаа байхгүй юу. Манай бүлэг дээр жишээ нь дэд хороо гэдэг юм уу, эсвэл сонсгол хийх гэж байгаа чиглэлээр ажиллана. Тэгээд энд орж ажиллах гишүүдийг ярилцсан юм байхгүй шүү дээ.

Ж.Батжаргал дарга сууж байна.

Тийм учраас үүнийг ч гэсэн цаашдаа бүлэг дээр ярих ёстой юм болов уу. Ядаж гишүүд энэ материалтайгаа эхлээд танилцмаар байгаа байхгүй юу.

Тэгээд хэн орж ажиллах юм. Янз бүрийн юмаа бодолцсон ч тэр. Зүгээр шууд тараагаад л тохиролцсон юм уу, эсвэл яг хаанаас хэн санаачлаад гэдгийг нь яг бүрэн шийдэгдсэн юм уу? асуудал байна.

Тэгэхээр энэ асуудлыг ч гэсэн хойшлуулъя. Ядаж материалтайгаа танилцмаар байна. Энэ орж ажиллах гишүүд нь бүлгүүдээс өгсөн юм уу, эсвэл сайн дураараа ороод байгаа юм уу? Үүнийгээ тодруулж байж асуудлыг хэлэлцэх нь зүйтэй болов уу гэж бодоод байна.

Н.Наранбаатар: С.Лодойсамбуу гишүүн. Санал гаргах ёстой доо. Дэгээрээ.

С.Лодойсамбуу: Нийслэлийн төсөвтэй холбоотой дэд хороо байгуулах асуудлыг хойшлуулъя гэдэг санал гишүүд хэлж байх шиг байна. Үүнийг хойшлуулахгүй байя гэдэг санал гаргаж байгаа юм. Улсын Их Хурлын гишүүд хоорондоо ярилцаад үүнийг ер нь бид харах ёстой юм байна. Нэг хянан шалгаад үзье. Юу болоод байгаа юм. Хуульд нийцэж байгаа юм уу гээд үзье гээд гишүүд нь саналаа гаргаад хуулийн дагуу өгч байна шүү дээ.

Тэгээд үүнийг бүлгээрээ авч хэлэлцье гэдэг санал гарч байх шиг байна. Би саналыг нь хүндэтгэж байна. Гэхдээ эргээд энэ намынхны л асуудлыг бид нэг харах гээд байна шүү дээ.

Тэгээд одоо харах гээд, харуулах гээд байгаа нам нь бид нэг юугаа яаж харуулах вэ гэдгээ ярилцаадахъя гэж байгаа юм шиг сонсогдоод байна л даа. Одоо нийслэлийн төсөв бол 2016 онд 440 хавьцаа тэрбум байсан, одоо 4 их наяд төгрөг. Гадаад зээл нийлээд бараг 7 их наяд төгрөг. Нийт төсөв гадаад зээлтэйгээ нийлэх юм бол бараг 10 гаруй, 11 их наяд төгрөг болсон.

Тэгээд тэрний зарцуулалт юу болоод байгаа юм? Зүв зүгээр байгаа замыг хуулж хаяад л, зүв зүгээр байгаа бордюруудыг өөрчлөөд л яваад байдаг. Ажил хийгээд байна гээд л.

Энэ яг зөв зохистой зарцуулж байна уу гэдгийг яаралтай үзмээр байна шүү дээ.

Ингээд хойшлуулаад яваад байж болох юм уу, үгүй юм уу? Тэгээд үүнийг бол Байнгын хорооны дарга уг нь нэгэнт гишүүд бүрэн эрхийнхээ хүрээнд ярилцаад байгуулъя гэж байгаа дээр бол байгуулаад л өгсөн нь дээр юм биш үү дээ.

Н.Наранбаатар: Да.Цогтбаатар гишүүн.

Да.Цогтбаатар: Мөн энэ хэлэлцэх асуудлын тов дараалалд орсон дэд хорооны бүрэлдэхүүний асуудлыг хойшлуулах санал гаргаж байна.

Ардчилсан намын бүлгийн дарга түр чөлөөтэй байгаа. Тэгээд бүлгийн даргатай болон бүлэгтэй ярилцаагүй байгаа. Уг нь ярилцъя гэдэг байдлаар өмнө нь ярилцсан.

Тэгээд энэ асуудлыг хойшлуулж өгнө үү гэдэг санал гаргаж байна.

Н.Наранбаатар: Ж.Золжаргал гишүүн. Хуруугаа уншуулсан уу? Ж.Золжаргал гишүүний микрофоныг өгөөрэй.

Ж.Золжаргал: Нийслэлийн төсөв, хөрөнгө оруулалтын төслүүдийн хэрэгжилт, хууль тогтоомжид нийцэж байгаа талаар ерөнхий хяналтын сонголт байгуулах ажлын хэсэг байгуулах дараалал орж ирсэн байгаа.

Тэгээд үүнийг хойшлуулах санал гарч байх шиг байна. Монгол Улсын Үндсэн хуульд олгосон эрхээр ерөнхий хяналтын сонголыг санаачлах эрх нь Улсын Их Хурлын гишүүдэд байгаа. Улсын Их Хурлын тухай хууль дээр 15-аас дээш гишүүн гарын үсэг зурсан бол зохион байгуулна. 25 гишүүн гарын үсэг зурсан.

Тэгээд зохион байгуулах чиглэл Улсын Их Хурлын даргаас өгөгдсөн. Өргөдлийн байнгын хороо энэ асуудлыг яриад ажлын хэсгийг байгуулах дараалалтай байгаа.

Энд Улсын Их Хурлын гишүүд бүрэн эрхийнхээ хүрээнд Үндсэн хуулийн болоод Улсын Их Хурлын тухай хуулийн дагуу явж байгаа үйл ажиллагаа. Өргөдлийн байнгын хорооны гишүүдийн өөрсдийнх нь шийдэх асуудал гэж бодож байна. Энд нэг их айхтар намын бүлгээр яриад байх тийм улс төрийн шинж чанартай асуудал байхгүй шүү дээ.

Орсон байгаа тэр ажлын хэсэгт хэн хэн орж болох вэ гээд нөгөө 25 гишүүдээс гарын үсэг зурсан. Аль аль намын л хүмүүс байгаа. Өргөдлийн байнгын хорооныхонтой санал солилцоод тэнд 7 хүний ажлын бүрэлдэхүүн, 3 нь Монгол Ардын намаас, 2 нь бусад намуудыг төлөөлсөн байдалтай байгаа.

Үүнийг хуулийнхаа хүрээнд, дэгийнхээ хүрээнд хэлэлцээд шийдээд явсан нь дээр байх. Хойшлуулж хэрэггүй. Өнөөдөр шийдсэн нь дээр байх гэдэг саналыг хэлмээр байна.

Нийслэл дээр хэрэгжиж байгаа нийт төслүүдийн хэмжээ чинь одоо улсын төсвийн гуравны нэг орчим хэмжээний мөнгөн дүн эргэлдэж байгаа. Улсын хэмжээний хөрөнгө оруулалтын тал нь тэнд байгаа.

Тэгэхээр энэ зүгээр хэмжээний хувьд алдаа гарахад улсын төсөв дээр ачаалал ирнэ. Эргэн төлөлт, буцаалт, эдийн засагт маш том нөлөө үзүүлнэ. Би муу албатай гэж хэлээгүй л дээ. Сайн байж болно. Гэхдээ юманд эрсдэл гэж байдаг. Энэ хэмжээ чинь бүр хэтэрхий том болсон байна.

Тийм учраас улсын төсөв, энэ улс орны асуудлыг, гадаад дотоод бодлогыг бүгдийг нь хамарч байдаг Улсын Их Хурал дээр хяналт тавих асуудал, эрхийнхээ дагуу зохион байгуулах саналыг гаргасан болно.

Тэгээд битгий хойшлуулаарай гэж хүсмээр байна.

Н.Наранбаатар: Гишүүд горимын санал гаргалаа. Одоо гишүүд горимын санал гаргасан учраас санал хураагаад хойшлуулах уу, үгүй юу гэдгээ шийдээд явна.

Эхлээд Да.Цогтбаатар гишүүн санал гаргасан. Нэг бүрчлэн хэлэлцэх асуудалтай холбоотой гаргасан саналыг санал хураалтаар шийднэ. Гишүүд санал хураалтдаа бэлтгээрэй.

Да.Цогтбаатар гишүүний гаргасан саналын дагуу.

Нэг.Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл. Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 05 дугаар сарын 07-ны өдөр өргөн мэдүүлсэн. Хэлэлцэх эсэх. Энэ асуудлыг хойшлуулах гэсэн саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

18 гишүүнээс 10 гишүүн дэмжиж, 55.6 хувиар дэмжигдлээ.

Ж.Батсуурь гишүүнийг дэмжсэнээр аваарай.

Дараагийн санал нь, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл. Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 05 дугаар сарын 07-ны өдөр өргөн мэдүүлсэн. Хэлэлцэх эсэх. Санал хураалт. /алх цохив/

11 гишүүн дэмжиж 61.1 хувиар дэмжигдлээ.

Гуравт нь, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл. Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 05 дугаар сарын 07-ны өдөр өргөн мэдүүлсэн. Хэлэлцэх эсэх. Санал хураалт. /алх цохив/

Д.Жаргалсайхан гишүүнийг дэмжсэнээр аваарай.

18 гишүүнээс 10 гишүүн дэмжиж 55.6 хувиар дэмжигдлээ.

Дараагийнх нь, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл. Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 05 дугаар сарын 07-ны өдөр өргөн мэдүүлсэн. Хэлэлцэх эсэх. Хойшлуулах томъёоллоор санал хураая. Санал хураалт. /алх цохив/

12 хүн дэмжиж 66.7 хувиар дэмжигдсэн.

Дараа нь, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл. Монгол Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж нарын 5 гишүүнээс 2025 оны 06 дугаар сарын 19-ний өдөр өргөн мэдүүлсэн. Хэлэлцэх эсэх асуудлыг хойшлуулах саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

38.9 хувиар дэмжигдсэнгүй.

Дараа нь, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл. Монгол Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа нарын 32 гишүүнээс 2026 оны 03 дугаар сарын 30-ны өдөр өргөн мэдүүлсэн. Хэлэлцэх эсэх асуудлыг хойшлуулах саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

77.8 хувиар дэмжигдлээ.

Дараагийн санал нь, П.Сайнзориг гишүүний гаргасан саналаар санал хураалт явуулж эхэлье.

Байнгын хорооны тогтоолын төсөл гээд” Ерөнхий хяналтын сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай” асуудлыг хойшлуулах саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

7 хүн санал өгч, 38.9 хувиар дэмжигдсэнгүй.

Дараагийн санал нь, П.Сайнзориг гишүүний гаргасан саналын дагуу Байнгын хорооны тогтоолын төсөл. “Ажлын хэсэг байгуулах тухай” асуудлыг хойшлуулах гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

33.3 хувиар дэмжигдсэнгүй.

Дахиад Да.Цогтбаатар гишүүний гаргасан горимын санал байгаа.

Да.Цогтбаатар гишүүний гаргасан горимын саналын саналаар Дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай асуудлыг хойшлуулах гэсэн саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

10 хүн дэмжиж 55.6 хувиар дэмжигдлээ.

Саяын горимын санал гараад, хэлэлцэх асуудлаас зарим асуудлууд хасагдаад, одоо үлдэж байгаа асуудлуудыг танилцуулъя.

Одоо хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл. “Ерөнхий хяналтын сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай”.

Хоёр.Байнгын хорооны тогтоолын төсөл. “Ажлын хэсэг байгуулах тухай”.

Гурав.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл. Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж нарын 5 гишүүн 2025 оны 06 сарын 19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх.

Дөрөв.“Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл. Улсын Их Хурлын гишүүн Х.Пунсалмаа нарын 13 гишүүн 2026 оны 05 дугаар сарын 07-ны өдөр өргөн мэдүүлсэн. Хэлэлцэх эсэх.

Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүдийн саналыг аваад баталсан.

Хэлэлцэх асуудалдаа оръё. /алх цохив/

Эхний асуудал. “Ерөнхий хяналтын сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл
/Ерөнхий хяналтын сонсголын тов тогтоох,
сонсгол даргалагчийг сонгох тухай/

Монгол Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргал нарын 25 гишүүнээс 2026 оны 05 дугаар сарын 01-ний өдөр нийслэлийн 2024-2026 оны төсвийн зарцуулалт, хөрөнгө оруулалтын төслүүдийн хэрэгжилтийн талаар ерөнхий хяналтын сонсгол зохион байгуулах хүсэлтээ Монгол Улсын Их Хурлын даргад ирүүлсэн.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-д Улсын Их Хурал хууль тогтоомжийн хэрэгжилтийг дүгнэх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах, түүний удирдах албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавих зорилгоор ерөнхий хяналтын сонсголыг явуулна гэж, мөн хуулийн 29.2-т Улсын Их Хурал нь Улсын Их Хурлын 15-аас доошгүй гишүүн хүсэлт гаргасан тохиолдолд ерөнхий хяналтын сонсголыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасны дагуу заавал явуулна гэж заасны дагуу дээрх сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай Байнгын хорооны тогтоолын төслийг боловсруулсныг Та бүхэнд тараасан.

Байнгын хорооны тогтоолын төслийг уншиж танилцуулъя.

“Ерөнхий хяналтын сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай”.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалт, 37 дүгээр зүйлийн 37.1.6 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.1.2 дахь заалт, 119.1.2 дахь хэсэг, 121 дүгээр зүйлийн 121.1, 121.13 дахь хэсэг, 122 дугаар зүйлийн 122.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэг, Нийтийн сонсголын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэг, 20 дүгээр зүйлийн 20.1 дэх хэсэгт заасныг үндэслэн Төсвийн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1. Нийслэлийн 2024-2026 оны төсвийн зарцуулалт, хөрөнгө оруулалтын төслүүдийн хэрэгжилт, холбогдох хууль тогтоомжид нийцсэн байдлын талаар ерөнхий хяналтын сонсголыг ... өдөр зохион байгуулахаар тогтоосугай.

2. Нийслэлийн 2024-2026 оны төсвийн зарцуулалт, хөрөнгө оруулалтын төслүүдийн хэрэгжилт холбогдох хууль тогтоомжид нийцсэн байдлын талаар Ерөнхий хяналтын сонсгол даргалагчаар Монгол Улсын Их Хурлын гишүүн ... сонгосугай.

3. Ерөнхий хяналтын сонсголын зарыг нийтэд мэдээлж, бэлтгэл ажлыг ханган холбогдох хууль журамд заасны дагуу зохион байгуулахыг Монгол Улсын Их Хурлын Тамгын газар (Д.Өлзийсайхан)-т даалгасугай.

Төсвийн байнгын хорооны дарга Н.Наранбаатар гэсэн тогтоолын төсөл байна.

Байнгын хорооны тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асууж, санал гаргах гишүүд нэрсээ өгье.

Одоо нөгөө санал гарч ирээд тэгээд санал хураагаад шийднэ. Асуулт асуух гишүүд нэрсээ өгье.

Ж.Золжаргал гишүүнээр тасаллаа. Ж.Золжаргал гишүүн асуулт асууя.

Ж.Золжаргал: Би энэ ерөнхий хяналтын сонсголыг санаачилж, тэгээд гишүүд дэмжиж, 25 гишүүн гарын үсэг зурсан.

Тэгээд энэ тогтоол дээр ерөнхий хяналтын сонсгол даргалагчаар Жаргалсайханы Золжаргалыг сонгосугай гэж оруулах саналыг гаргаж байна.

Тэгээд аль нэг намын улс төрийн зорилго, нөлөөлөлд орохгүйгээр хараат бус байдлаар, гуравдагч өнцгөөс, тэгээд ерөнхий хяналтын сонсголыг чиглүүлж ажиллана гэдгээ илэрхийлье. Баярлалаа.

Н.Наранбаатар: Санал гаргаж байна. Ж.Золжаргал гишүүн сонсгол даргалагчаар санал гаргаж байгаа юм байна.

Товтой холбоотой санал хэлэх гишүүн байна уу? Ж.Золжаргал гишүүн, товтой холбоотой ямар санал байна? Ж.Золжаргал гишүүн.

Ж.Золжаргал: Ерөнхий цаглавар хуваарийг хараад бодоход 06 дугаар сарын 16, 17-ны өдөр л их боломжтой харагдаж байгаа.

Тэгээд нэлээн их бичиг баримт байж таарах байх. Ажлын хэсэг мэдээж ангилна.

Түүнээс биш бүх юм нь хутгалдаж орох боломж бол байхгүй. Гэхдээ 2 өдөр 16, 17-ны өдөр яг битүү ажиллаад таарах болов уу гэсэн саналтай байна. 2026 оны 06 дугаар сарын 16, 17 гэсэн саналтай байна.

Н.Наранбаатар: Ж.Золжаргал гишүүний саналын дагуу тогтоолын төслөөр санал хураалт явуулна.

Би танилцуулъя. Саяын Ж.Золжаргал гишүүний саналыг оруулаад.

1.Нийслэлийн 2024-2026 оны төсвийн зарцуулалт, хөрөнгө оруулалтын төслүүдийн хэрэгжилт холбогдох хууль тогтоомжид нийцсэн байдлын талаар ерөнхий хяналтын сонсголыг 2026 оны 06 дугаар сарын 16, 17-ны өдөр зохион байгуулахаар тогтоосугай.

2.Нийслэлийн 2024-2026 оны төсвийн зарцуулалт, хөрөнгө оруулалтын төслүүдийн хэрэгжилт холбогдох хууль тогтоомжид нийцсэн байдлын талаар Ерөнхий хяналтын сонсгол даргалагчаар Монгол Улсын Их Хурлын гишүүн Жаргалсайханы Золжаргалыг сонгосугай гэсэн өөрчлөлтийг тогтоолын төсөлд орууллаа.

Байнгын хорооны тогтоолын төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд байна уу? Үг хэлэх гишүүн алга байна. /алх цохив/

Гишүүд санал хураалтад бэлдээрэй.

“Ерөнхий хяналтын сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

18 гишүүнээс 8 гишүүн дэмжиж, 44.4 хувийн саналаар тогтоолын төсөл дэмжигдсэнгүй. /алх цохив/

Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа. /алх цохив/

Дараагийн асуудалдаа орно.

Н.Алтанхуяг гишүүн.

Н.Алтанхуяг: Улсын Их Хурлын гишүүд хуулийнхаа дагуу янз бүрийн ажлын хэсэг байгуулъя, комисс байгуулъя, хяналт хийгээд сонсгол явуулъя гээд эрхээ эдлэх гэхээр тэрнийг нь бид орж ирээд унагаагаад байж болдог юм уу?

Дээр бас нэг Туулын хурдны зам гээд нэг юм орж ирээд л Монгол Ардын намынхан нийлж байгаад унагаасан байхгүй юу.

Манай Байнгын хороон дээр тайлбар хийдэг хуулийн хүн байна уу? Бид ингэдэг юм. Нэг практик явдаг юм. Нэг асуудал хэлэлцээд тогтол гарлаа. Тэр асуудлаа олонхоороо дэмждэг.

Тэгээд хуучин тогтоолоо батлахаар тогтоол нь унаад байдаг байсан чинь асуудлыг олонхоороо шийдсэн бол тогтоолыг батлагдсанд тооцно гэдэг шиг одоо энэ юмыг батлагдсанд тооцоод явдаггүй юм уу?

Одоо бид гишүүдийнхээ эрхэнд, олонх нь цөөнхийнхөө эрхэнд халдаад, Улсын Их Хурлын гишүүдийн эрхэнд халдаад байж болох юм уу? Эсвэл ерөөсөө энэ Монгол Ардын нам бүх юмаа өөрсдөө хий гэж би хэлээд байгаа шүү дээ. Ингэж болох юм уу? Энэ чинь Их Хурал биш боллоо шүү дээ. Нэг намын юм боллоо. Энэ дээр одоо хуулийн тайлбар хийдэг хүн байхгүй юм уу? Яагаад сонин юм болдог юм? Үгүй ээ, тэгээд Их Хурлын гишүүдийг юу гэж мохоож байгаа вэ гэхээр чи өөрөө тэгээд хуулиа санаачлаач гээд. Санаачилж орж ирэхээр нь цөөнхийг нь унагаагаад явуулаад байдаг чинь болж байгаа юм уу?

Ер нь яагаад олон түмнээс төсөв, хөрөнгө оруулалтын юм нь нуугаад байдаг юм? Үүнийг яагаад ил тод ярьж болдоггүй юм? Тэр цаана нь ямар ялзарсан, илжирсэн юм байгаа юм? Яагаад үүнийг ярьдаггүй юм бэ? Би бол ёстой эсэргүүцэж байна. Үүнийг ингээд байх юм бол бид нар ер нь хуралд суухын хэрэг юу байдаг юм бэ? Эртээд бас тэгээ биз дээ. Банзрагчийн Түвшин гишүүн ээ. Үгүй ээ, ингэж болохгүй шүү дээ.

Хамаг асуудлаа хойшлуулъя. Үлдэж байгаа ганц асуудал дээр нь май чи гээд санал өгч байна. Үүнийг янзалж болохгүй юм уу, Н.Наранбаатар дарга аа. Та нар маань нэг яриад, эсвэл Ж.Батжаргал дарга аа, танайх бүлэг дээрээ нэг яриад.

Ер нь цөөнхөө яах юм? Ерөөсөө цөөнхгүйгээр амьдрах гэж байгаа юм уу? Энэ нөгөө хууль ном хэрэггүй юм уу? Их Хурал гэдэг институц байх юм уу, байхгүй юм уу? Эсвэл одоо нэг намын бүлэг шиг юм явах юм уу, яах юм? Би ийм санал хэлье. Энэ ер нь бараг горимын шахуу санал шүү дээ.

Тэгээд тэр комиссыг нь байгуулаад л явуулаач дээ. Юун тэнд яах гээд байгаа юм, юунаас нь айгаад байгаа юм.

Н.Наранбаатар: Ж.Батжаргал гишүүн санал хэлье.

Ж.Батжаргал: Үгүй ээ, үгүй. Энд угаасаа Их Хурлын тухай хууль дотроо байгаа юм.

25 гишүүн гарын үсэг зурсан бол хяналтын сонсгол угаасаа хуулиар явах ёстой. Тов даргалагч, түүний бэлтгэлийг хангах ажлын хэсэг энэ тэр нь байгуулагдах ёстой юм байна лээ. Түүнийгээ бүлэг дээрээ нэг ярья гээд нэг гишүүн санал гаргахаар үгүй ээ гэж байгаа байхгүй юу.

Тийм учраас би сая зориуд дэмжээгүй юм. Энэ асуудал чинь ерөөсөө над дээр яригдаагүй эд байхгүй юу. Огт.

Угаасаа бид хяналтын сонсгол хийх гэж байгаа бол тэр төсвийнх нь, хөрөнгө оруулалтынх нь юмыг үзэх гэж байгаа бол бүлэг Их Хурлын санхүүч, нягтлан бодогч гишүүдээ сонгож оруулж юмаа үзсэн шиг үзэх хэрэгтэй байгаа байхгүй юу. Тэр нь огт манай бүлэг дээр яригдаагүй учраас би сая дэмжихгүй байгаа юм.

Тэгээд үүнийг тэртээ тэргүй дараагийн хуралдаанаар оруулж ирж таараа. Ойлгомжтой. Тэр хүрээнд нь харин манайх бэлтгэлээ хангаж, тэр ажлын хэсэгт орох бүрэлдэхүүн энэ тэрээ тогтож оруулж ирье.

Энэ чинь ер нь яг нарийндаа бидний дэгийн хуулийн алдаа байгаа юм. Эс үйлдэхүйгээр асуудал унагаад байгаа байхгүй юу. Саяын дэмжээгүй улс дотор чинь ерөөсөө энэ дотор байж байгаагаас аягүй бол би ганцаараа шахуу байгаа байх. Бусад нь байхгүй гишүүд санал хураалтад оролцоод эсрэг өгчхөөд байгаа байхгүй юу. Энэ чинь. Тэгээд унаад байгаа эд шүү дээ, энэ чинь.

Үгүй ээ үгүй. Ярих ёстой байхгүй юу. Үүнийгээ. Ийм юм ярих гэж байгаа бол... /минут дуусав/

Н.Наранбаатар: Г.Ганбаатар гишүүн.

Г.Ганбаатар: Гурав дахь удаагаа боллоо шүү. Төсвийн байнгын хорооны дарга аа. Энэ асуудал.

Та санаж байгаа бол яг гурав дахь удаагаа ийм тохиолдол боллоо шүү. Хоёр дээр нь та эсрэг санал өглөө шүү. Байнгын хорооны даргын хувьд.

Би Ж.Батжаргал даргын ярьж байгааг гайхаж байна. Хэрвээ тийм байсан бол та өөрөө П.Сайнзоригор биш, та өөрөө хэлээд тэр ойлголцлоо хэлэхгүй ясан юм.

Парламент гэдэг чинь ойлголцол, зөвшилцөл, мэтгэлцээний талбар биш юм уу? Та нар тэгээд ерөнхий хяналтын сонсгол, эсвэл нийслэлийн төсөвтэй, эсвэл Туулын хурдны замын холбоотой бас нэг мэдээлэл авъя гэхээр яахаараа та нар дандаа иргэдийн мэдэх эрх, сонсох эрх, энэ олон нийтийн мэдэх эрх, энэ ил тод байдлын эсрэг халдаад байдаг юм бэ?

Юу бүгдийг нь дэмжсэн гэж. Сая өөрөө эсрэг өгөөд санал болгож байна. Үгүй ээ, тэгээд тийм бол өмнө нь хэлэхгүй ясан юм. Биш ээ. Тийм байсан бол та бүлгийн даргын хувьд өмнө нь хэлэхгүй ясан юм. Аан. Та нар үнэхээрийн нэг 10-аад жил хулгай зэлгий хийгээд ямарваа нэгэн юмны сонсгол, төсөвтэй холбоотой мэдээлэл хийе гэхээр бүгд унагадаг болжээ. Болохгүй шүү дээ. Та нар.

Харбины гэрээний тухай зүгээр нэг мэдэх эрхийг нь хангая гэсэн. Та нар унагасан. Туулын хурдны зам дээр та нар л олонхоороо унагасан шүү дээ.

Туулын хурдны зам дээр яалаа. Туулын хурдны зам дээр та хоёр дэмжиж байсан. Та нар унагасан шүү дээ. Одоо гурав дахиа болж байна гэж байна. Тэгэхээр ингэж явах юм уу, эсвэл бид хурлаа орхиод гарах юм уу? Та нар хэрвээ юу яадаг юм бол дангаараа үүнийгээ шийдээд яв л даа. Би одоо гурав дахь удаагаа аягүй бухимдалтай хандаж байна шүү дээ.

Өмнө нь хоёр удаа зүгээр л хэлсэн та нарт. Тэгвэл Ардчилсан намын бүлэг энд хуралд оролцох шаардлага байгаа юм уу? Ардчилсан намаас Төсвийн байнгын хорооны хуралд оролцох шаардлага байгаа юм уу? Н.Алтанхуяг дарга зөв л ярьж байна шүү дээ.

Нэг зүйлийг гурван удаа давтана гэдэг чинь та нарт айх, нуух, хаах юм байгаа учраас ингэж байгаа байхгүй юу.

Н.Наранбаатар: Дэгийн тухай хуулийн би 122 дугаар зүйлийг уншъя.

Сонсгол даргалагчийг сонгох тухай зохицуулалт байгаа юм. 122.1-д холбогдох Байнгын болон дэд хорооны хуралдаанаар сонсгол даргалагчийг, цаашид "сонсгол даргалагч" гэх, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар сонгоно гээд.

Сонсгол даргалагчийн эзгүйд түүний томилсон гишүүн сонсгол даргална гээд дэгийн зохицуулалттай юм байна.

Дараагийн хуралдаан дээрээ энэ асуудлыг ярина.

Дараагийн асуудал, “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг эхний асуудал дэмжигдээгүйтэй холбоотойгоор хэлэлцэх шаардлагагүй болсон.

Тийм учраас дараагийнхаа асуудалд орёе.

**Хоёр.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд
өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл**

/Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж нарын 5 гишүүн
2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн,
хэлэлцэх эсэх/

Дараагийн асуудал нь, Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж нарын өргөн мэдүүлсэн Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Ажлын хэсгийг оруулаарай.

Хуулийн төслийн талаарх танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Их Хурлын дэд дарга Б.Пүрэвдорж танилцуулна.

Таныг микрофонд урьж байна. 4 номерын микрофон нээгээрэй.

Б.Пүрэвдорж: Их Хурлын гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Байнгын хорооны даргад баярлалаа.

Нэмэгдсэн өртгийн албан татварын хувь хэмжээг 5 хувь болгох, буцаан олголтыг 2 хувь болгох, өөрөөр хэлбэл нийтдээ 3 хувийн татварыг төлөх агуулга бүхий хуулийг 2018 онд өргөн барьсан. 2020 онд Монгол Ардын Намын бүлэг унагаасан байгаа.

2023 онд дахин өргөн барьсан. Дахиад 2024 онд энэ хуулийг хэлэлцээгүй.

Тэгээд шинэ парламент байгуулагдсантай холбоотойгоор энэ хуулийг дахин өргөн барьж байгаа.

Нэмэгдсэн өртгийн албан татварын хууль анхнаасаа аж ахуйн нэгж, иргэдийн үйл ажиллагааг бүртгэх зориулалттай татвар. Гэвч өнөөдрийн байдлаар нийт татвар хураамжийн 20 хувьд хүрэхээр ард түмний нуруун дээр, аж ахуйн нэгжийн нуруун дээр дарамт болсон татвар болж хувирсан байна.

Монгол Улс нэгдүгээрт нь хөдөө аж ахуйн орон, нөгөө талаар манай Монгол Улс хэрэглэгч орон. Өөрөөр хэлбэл хөдөө аж ахуйн бараа, бүтээгдэхүүнүүд, малчдын нийлүүлж байгаа мах, сүү, ноос ноолуур, арьс шир, мөн түүнчлэн хүнс, ногоо зэрэг тариаланчдын зах зээлд оруулж байгаа бараа, бүтээгдэхүүнүүд нийт зах зээлийн 30 хувьд ямарваа нэгэн нэмэгдсэн өртгийн албан татвар төлөх, нэмэгдсэн өртгийн албан татварын баримтгүйгээр орж ирж байгаа.

Хоёрдугаар нь, манайх хэрэглэгч орон. Ихэнх бараа Бүгд Найрамдах Хятад Ард Улсаас импортлогддог. Та бидний хэрэглэж байгаа цамц, костюм аль эсвэл гутал юм уу, энэ бүх зүйл гаалийн байгууллагаар албан ёсоор нэг бүрчлэн мэдүүлж орж ирдэггүй.

Өөрөөр хэлбэл Замын-Үүдээр орж ирж байгаа бараа, бүтээгдэхүүн ямар том ачааны машин дүүрэн бараа орж ирж байгаа мөртлөө нэг, хоёр нэр төрлийн бүтээгдэхүүнээр мэдүүлэгддэг. Өөрөөр хэлбэл жин ихтэй, үнэ багатай цемент, арматур зэрэг бараа, бүтээгдэхүүний нэрээр орж ирдэг.

Тэгээд тэр орж ирж байгаа бүх бараанууд бүгдээрээ Нарантуулын зах дээр ямарваа нэгэн бүртгэлгүйгээр борлуулагддаг. Энэ нь Монгол Улсын өнцөг булан бүрд түгээгдэж худалдаанд ямарваа нэгэн нэмэгдсэн өртгийн албан татварын баримтгүйгээр орж байгаа.

Ер нь хэрэглэгч талаасаа, мөн түүнчлэн хөдөө аж ахуйн орон учраас орж ирж байгаа бараа, бүтээгдэхүүн бүгдээрээ зах зээл дээр ямарваа нэгэн нэмэгдсэн өртгийн албан татварын баримтгүйгээр орж ирж байгаа нь бараа, бүтээгдэхүүнийг бүрэн бүртгэх ямарваа нэгэн боломжгүй болгож байгаа юм.

Энэ юунаас үүдэж байна вэ гэвэл нэмэгдсэн өртгийн албан татварын татвар 10 хувь байгаа, өндөр байгаагаас шалтгаалж бараа, бүтээгдэхүүнээ бүрэн мэдүүлэх, бүртгүүлэх үйл ажиллагаа бүрэн саатаж байна гэсэн үг.

Өнөөдрийн байдлаар Монгол Улсад нийтдээ 270 мянган аж ахуйн нэгж байгаа. Түүний 116 мянган аж ахуйн нэгж нь идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа. Үүнээс 80 мянга орчим аж ахуйн нэгж нь нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчөөр бүртгүүлсэн боловч 50 саяын хязгаараас шалтгаалж ихэнх нь нэмэгдсэн өртгийн албан татвар төлдөггүй аж ахуйн нэгжүүд байгаа.

Тийм учраас дээрээс нь 250 мянган хувь иргэн бизнес эрхэлдэг, хувиараа хөдөлмөр эрхэлдэг. Энэ хүмүүсээс маш цөөхөн хүмүүс нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчөөр бүртгүүлж энэ татварыг төлдөг.

Энэ нь юунаас шалтгаалж байна вэ гэвэл нэмэгдсэн өртгийн албан татварын татвар өндөр байгаагаас шалтгаалж нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчөөр бүртгүүлэх үйл ажиллагаа ерөөсөө явахгүй байна гэсэн үг. Бараа, бүтээгдэхүүнээ хууль ёсны дагуу бүртгүүлж үйл ажиллагаа явуулахгүй байна гэсэн үг.

Тэгэхээр нэмэгдсэн өртгийн албан татварын татвар иргэдэд, аж ахуйн нэгжүүдэд маш тийм дарамт болж байгаа үндсэн шалтгаан бол нийт татварын 20 хувийг төсөвт оруулдаг мөртлөө дөнгөж 5.3 тэрбум төгрөгийн Монгол Улс даяар нэмэгдсэн өртгийн албан татварын өртэй байгаа.

Энэ нь юу вэ гэвэл тэр аж ахуйн нэгж, иргэдээс тэр татварын өрийг хусаад татаж авч байна л гэсэн үг. Ямарваа нэгэн асуудалгүйгээр л дансыг нь хааж байгаад, үйл ажиллагааг нь хааж байгаад, бүх дансыг нь, бүх хөрөнгийг нь хурааж байгаад энэ татварыг бүгдийг нь төлүүлж байгаад үйл ажиллагаа цаашаа явж байна гэсэн үг.

Ийм учраас ард иргэд дотор энэ нэмэгдсэн өртгийн албан татварын татвар маш өндөр байна. Үүнийг багасгах нь зүй ёсны юм.

Тэгээд үүний үр дүнд нэмэгдсэн өртгийн албан татварын татвар 5 хувь байгаад буцаан олголт нь 2 хувь, үндсэндээ 3 хувийн татвар төлөх юм бол энэ татварын бааз суурь чинь хамаагүй өргөжинө.

Өөрөөр хэлбэл хилээр орж ирж байгаа, тэр хөдөө аж ахуйн зүг талаас орж ирж байгаа тэр бараа, бүтээгдэхүүнүүд бүгдээрээ нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчөөр бүртгүүлж, бүгдээрээ хууль ёсны дагуу татвараа төлөөд үйл ажиллагаа явуулах сонирхол иргэн, аж ахуйн нэгжид бүрэн байна.

Энэ хууль дээр гол зүйл нь уул уурхайн бүтээгдэхүүнүүд, мөн түүнчлэн архи, тамхи 10 хувиараа үлдэнэ. Үлдсэн бараа, бүтээгдэхүүнүүд, үйлчилгээнүүд 5 хувиар татвар төлөх боломжтой болох юм. Ингэсний үр дүнд татварын орлого 1.5 их наядаар буурах боловч буцаад татварын бааз суурийг өргөжүүлсний үндсэн дээр татварын орлого улам нэмэгдэх нөхцөл байдал бий болж байгаа юм.

Энэ нь эдийн засагт, дээрээс нь аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг илүү сайжруулахад маш том дэмжлэг болно гэж үзсэний үндсэн дээр, дээрээс нь Ардчилсан намын 2020 оны болон 2024 оны мөрийн хөтөлбөрт орсон учраас энэ хуулийн төслийг 4 гишүүний хамт өргөн барьсан байгаа юм.

Тэгээд гишүүд Та бүхнийг дэмжиж, энэ хуулийг Улсын Их Хурлаар хэлэлцүүлэхийг дэмжиж өгнө үү гэж хүсэж байна. Баярлалаа.

Н.Наранбаатар: Б.Пүрэвдорж даргад баярлалаа. Танилцуулгатай холбоотой асуулт асуух гишүүд нэрсээ өгье.

Г.Ганбаатар гишүүнээр тасаллаа. Ж.Батжаргал гишүүн асуулт асууна.

Ж.Батжаргал: Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Б.Пүрэвдорж гишүүн нэр бүхий 3 гишүүдтэй хамт боловсруулж өргөн мэдүүлсэн юм билээ.

Хуулийн төсөл юмнуудыг үзсэн.

Тэгэхээр одоо нэмэгдсэн өртгийн албан татварын татвар 10 байгааг 5 гэдэг ерөөсөө тийм ганцхан зохицуулалттай хуулийн төсөл өргөн баригдаж орж ирсэн юм.

Өнөөдөр Монгол Улсын төсөвт 6.2 их наядын орлого нэмэгдсэн өртгийн албан татвараар дамжиж орж байна. Түүний 3.4 нь дотоодын нэмэгдсэн өртгийн албан татвараараа, 2.8 нь импортоороо бараа, бүтээгдэхүүнүүдээсээ орж ирж байгаа.

Сая Монгол Улсын Засгийн газар татварын багц хууль өргөн бариад, тэр дотор нэмэгдсэн өртгийн албан татвартай холбоотой нэлээн томоохон өөрчлөлтүүд ороод ирсэн.

Нэмэгдсэн өртгийн албан татварыг урьдчилж аваад байгаа явдлыг зогсооё.

Тийм учраас гаалиар орж ирж байгаа бараа, бүтээгдэхүүн дээр нэмэгдсэн өртгийн албан татварыг нь тэнд нь шууд хураадгаа болиод, уг хуулийн этгээдүүд бараа, бүтээгдэхүүнээ борлуулсантай нь уяж нэг сарын хугацаанд нэмэгдсэн өртгийн албан татварыг нь хоишлуулаад, тэгээд борлуулалттайгаа уялдуулж татвараа төлөхөөр зохицуулалт орж ирж байгаа.

Энэ үүргээ сайн гүйцэтгэвэл дахиад үргэлжилж болохоор орж өгсөн. Нэг сарын хугацаагаар.

Дээр нь нэмэгдсэн өртгийн албан татварын босгыг 50 саяыг 400 сая болгоё гэж оруулж ирсэн. Үүнийг бид бүлэг дээр үзсэн. Нэлээн тооцоо судалгаа юмнуудыг нь харсан. Нэгэнт энэ хуулиудыг ирэх долоо хоногт хэлэлцье гэдгээр сая санал гараад хойшиллоо.

Тийм учраас би Б.Пүрэвдорж гишүүний хуулийг ч гэсэн ирэх долоо хоногт нэмэгдсэн өртгийн албан татварын хуультай нь цуг уяж хэлэлцэх нь зөв юм байна.

Тэгээд энэ хүний оруулж ирээд байгаа тэр 10-ыг 5 болгоод байгаа юм нь төсөв дээр ямар ачаалал ирэх юм? Өөрийнх нь саяын хийж байгаа мэдээлэлтэй уялдуулаад тамхи, архи, уул уурхайн тоног төхөөрөмж, юмнуудын нэмэгдсэн өртгийн албан татвар нь 10-аараа байхаар, бусад бараа, бүтээгдэхүүн 5 байхаар гэж өөрөө сая мэдээлэл дотроо хэллээ.

Тэрийг нь би олж харахгүй байгаа. Яг үнэнийг хэлэхэд. 10 байсан татварыг 5 болгочоод л байгаа.

Тийм учраас Монгол Ардын намын бүлэг ажлын 4 хоногийн завсарлага авъя.

Ирэх нэг дэх өдрийн хуралдаанаар энэ асуудлыг, өөрийнх нь мэдээллийг бүлэг дээр сонсоод, тооцоо судалгаануудыг нь дахиж нэг нягталж үзээд, тэгээд Засгийн газраас өргөн багсан хуультайгаа цуг хэлэлцээд явъя.

Н.Наранбаатар: Б.Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: Хамтдаа явъя, тэр нь бол зөв.

Н.Наранбаатар: Эхлээд хариулах уу? Б.Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: Ер нь архи, тамхи, уул уурхайн бүтээгдэхүүнийг 10 хувиар хэвээр байлгах энэ асуудлыг бол яг энэ ажлын хэсэг гараад хэлэлцүүлгийн явцад санал гаргаад оруулахаар явж байгаа.

Тэгээд дээрээс нь яг үүнтэй холбоотой тооцоолол, төсөв дээр ирж байгаа ачааллууд болон ямар ямар асуудал үүсэж байгаа талаар нарийн тооцооллууд бүгдээрээ байгаа. Тийм.

Ер нь нэмэгдсэн өртгийн албан татварыг 5 хувь болгох, буцаан олголт нь 2 хувь байх, үндсэндээ 3 хувь татвар төлөх энэ хуулийн төслийг татварын багц хуультай хамтатгаж хэлэлцээд, тодорхой ойлголцолд хүрсний үндсэн дээр явах нь зүйтэй гэж би хууль санаачлагчдын хувьд үзэж байгаа.

Тэгээд би сая долоо хоногоор энэ багц хууль хойшлогдсоныг би мэдээгүй байна. Би энэ Байнгын хорооны гишүүн биш учраас.

Тийм учраас Ж.Батжаргал гишүүний саналыг дэмжиж байна.

Тэгээд танай бүлэг дээр ороод энэ асуудлаараа тодорхой мэдээллүүдийг хийгээд, үүний үр дүнд тодорхой хэмжээгээр ард түмэн дээр ирж байгаа нэмэгдсэн өртгийн албан татвар чинь яг амьдрал дээр хамгийн том ачаалал болж байгаа шүү дээ.

Жишээ нь, нэг томоохон барилга барьж байгаа компани дээр нийтдээ 20 гаруй жижиг ажлын багууд очиж ажиллаж байгаа. Тэд нар бүгдээрээ "захирал аа, НӨАТ-гүй юмаа, энэ төлбөрөө төлөөч ээ" л гэдэг ийм л асуудлыг бүгдээрээ ярьж байгаа. Тэр дотроос нэг нь ч "НӨАТ-тай ажил үйлчилгээгээ авна шүү" гэдэг тийм компани ерөөсөө байхгүй байгаа байхгүй юу даа.

Тийм учраас нэмэгдсэн өртгийн албан татварыг 5 хувь болгосны үр дүнд, татварын бааз суурийг нэмэгдүүлсний үр дүнд илүү татварын орлого буурахгүй ээ, ачаалал буурахгүй ээ л гэдэг тооцоолол гарсан байгаа.

Тэгээд Ж.Батжаргал гишүүний саналыг дэмжиж байна.

Н.Наранбаатар: Энэ асуудал дээр Монгол Ардын намын бүлгээс 4 хоногийн завсарлага авах хүсэлтийн дагуу 4 хоногийн завсарлага өглөө. /алх цохив/

Н.Алтанхуяг гишүүн, микрофон өгөөч.

Н.Алтанхуяг: Их Хурлынхан, Тамгын газрынханд. Улсын Их Хурлын гишүүн төсөв мөнгөтэй холбоотой асуудлаар хуулийн төсөл санаачилж болж байгаа билүү? Нэг.

Хоёрдугаарт, Эрүүгийн хуульд Их Хурлын гишүүд санаачилга гаргаад оруулж болж байгаа билүү?

Би сүүлийн үед нэг юм ойлгохоо байгаад байгаа байхгүй юу. Би болохоор болдоггүй гэдэг ойлголттой яваад байгаа. Би өөрөө Сангийн сайд хийж байсан хүн учраас Их Хурлын энэ нэг заалтыг би зөв гээд ойлгоод байдаг байхгүй юу.

Тэгэхээр бид чинь янз янзаар хувь процентоо янз бүрээр хийгээд ороод ирээд байгааг Улсын Их Хурлын Тамгын газар нь оруулаад байж болж байгаа юм уу гэж би нэг иймэрхүү санаатай юм хэлж байгаа юм. Өнөөдөр хариулахгүй гэвэл тэр л биз.

Ер нь үүнийг нэг анхааралдаа авчих.

Хоёрдугаарт, би Эрдэнэтийн тэр П.Цагааны хулгайлаад авсан юмаар нэг тогтоолын төсөл оруулсан чинь Улсын Их Хурлын Тамгын газар нөгөө талын туйлыг нь хэлж байна. Энэ Н.Алтанхуягийн оруулсан төсөл бол хувийн өмчид халдсан, Үндсэн хууль зөрчсөн гэж дүгнэлт гаргаж байгаа.

Ингээд ер нь бид нэг жаахан дампуураад байгаа юм биш үү. Улсын Их Хурлын Тамгын газрын хуульчид Улсын Их Хурлын гишүүний санаачилсан тогтоолын төсөлд Үндсэн хууль зөрчсөн гэдэг дүгнэлт гаргаж байна гэдэг бол бас л болохоо байгаад байгаа юм. Би танин мэдэхүйн юм хэлж байна шүү. Надад хариулт өгөхгүй байж болно. Би хэлье.

Ер нь та нар үүнийг анхааралдаа ав л даа. Танай бүлэг яахаараа энэ дээр орж ирж байгаа хуулийг хэлэлцэхгүй явж байдаг юм бэ? Бас. Одоо Ардын намын бүлгээ загнаад уналаа, больё.

Н.Наранбаатар: Б.Пүрэвдорж гишүүн хариулъя.

Б.Пүрэвдорж: Хууль тогтоомжийн тухай хуулиар Их Хурлын гишүүний хууль санаачлах тодорхой хүрээг хумьсан байгаа.

Тэгэхдээ хууль өөрчлөх тухай асуудал дээр бол байхгүй. Хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг санаачилж болно. Шинэчилсэн найруулга болохгүй. Жишээ нь, Татварын хууль дээр бид шинэчилсэн найруулгыг оруулж болохгүй. Эрүүгийн хууль юм уу. Тийм ээ. Хэд хэдэн хуулиудыг заасан байдаг.

Энэ хуульд шинэчилсэн найруулгыг оруулж болохгүй. Харин хуульд өөрчлөлт оруулах нь Их Хурлын гишүүний бүрэн эрхэд бүрэн байгаа.

Н.Наранбаатар: Б.Гандулам ахлах зөвлөх хуулийн тайлбар хэлээдэх.

Б.Гандулам: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн мэндийг хүргэе.

Н.Алтанхуяг гишүүний асуусан асуултад хариулья.

Төсвийн байнгын хорооны ахлах зөвлөх Б.Гандулам.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 36 дугаар зүйлд хууль санаачлах эрхийн хүрээ хязгаарыг зааж өгсөн байгаа.

36.1-д нь доор дурдсан хууль тогтоомжийн төслийг дараах хууль санаачлагч санаачилна гээд.

36.1.1 нь Улсын Их Хурлын үйл ажиллагаа, хуралдааны дэгтэй холбоотой хууль тогтоомжийн төслийг зөвхөн Улсын Их Хурлын гишүүн санаачлах ба бусад хуулийн төслийг өргөн мэдүүлэх, Улсын Их Хурлаар хэлэлцэн батлахдаа дагалдах хэлбэрээр Улсын Их Хурлын үйл ажиллагаа, хуралдааны дэгтэй холбоотой хууль тогтоомжийг өөрчлөхийг хориглоно.

36.1.2 нь төсвийн хүрээний мэдэгдэл, улсын төсөв, түүний тодотгол, гүйцэтгэл, хөгжлийн бодлогын болон төлөвлөлтийн баримт бичиг, түүнчлэн төрийн болон орон нутгийн өмч, татвар, эрүү, иргэн болон зөрчлийн тухай анхдагч хууль, шинэчилсэн найруулга болон Засгийн газар санаачлахаар Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд заасан асуудлаар хууль тогтоомжийн төслийг зөвхөн Засгийн газар санаачилна гэж заасан байгаа.

Энэ анхдагч болон шинэчилсэн найруулга гэж бүр тодруулж өгсөн. Нэмэлт, өөрчлөлт болно.

Н.Наранбаатар: Дараагийн асуудалдаа оръё.

Гурав. “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай”

Улсын Их Хурлын тогтоолын төсөл

/Улсын Их Хурлын гишүүн Б.Пунсалмаа нарын 13 гишүүн

2026.05.07-ны өдөр өргөн мэдүүлсэн,

хэлэлцэх эсэх/

Монгол Улсын Их Хурлын гишүүн Х.Пунсалмаа нарын 13 гишүүнээс өргөн мэдүүлсэн “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулья.

Улсын Их Хурлын гишүүн Х.Пунсалмаа, Б.Нэргүй Улсын Их Хурлын гишүүний зөвлөх, Д.Амарбаясгалан Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн зөвлөх, Ж.Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Я.Өнөртүвшин “Зам, тээврийн хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын ерөнхий инженер, Э.Балт “Зам, тээврийн хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын Бодлогын хэрэгжилт, зураг төслийн магадлал, стандарт, норм, нормативын хэлтсийн дарга, Д.Мөнхбаатар “Барилгын хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал, З.Энх-Оргил “Барилгын хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын ерөнхий инженер, Г.Мөнхболд “Барилгын хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын Барилга, байгууламжийн зураг төслийн магадлал, зохион байгуулах хэлтсийн дарга, Т.Хонгор Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын шинжээч.

Тогтоолын төслийн талаарх танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Б.Пунсалмаа танилцуулна. 5 номерын микрофон.

Б.Пунсалмаа: Төсвийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

“Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн дэлгэрэнгүй танилцуулгыг танилцуулъя.

Монгол Улсын Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7-д төрийн санхүү, зээл, албан татвар, мөнгөний бодлого, улсын эдийн засаг, нийгэм, хөгжлийн бодлого, үндсэн чиглэлийг тодорхойлж, хөгжлийн болон үндэсний аюулгүй байдлын бодлогод нийцүүлэн боловсруулсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын төсөв, түүний гүйцэтгэлийн тайланг батлах гэж заасан.

Монгол Улсын Үндсэн хуулийн 26 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газар хууль санаачлах эрх эдлэх бөгөөд энэхүү эрхийн хүрээ хязгаарыг хуулиар тогтооно гэж Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 хэсэгт нэгдсэн хуралдаан энэ хуулийн 14.1.2, 14.1.3-д заасан мэдээллийг хэлэлцээд Улсын Их Хурлаас тодорхой шийдвэр гаргах болон хууль тогтоомжийн биелэлтийг хангуулахаар Засгийн газарт чиглэл өгөх шаардлагатай гэж үзвэл холбогдох Байнгын хороонд энэ талаар чиглэл өгч болно.

Мөн энэ зүйлийн 14.3-д Улсын Их Хурал хууль тогтоомжийн биелэлтийг хангуулахаар “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоол баталсан бол Засгийн газар уг тогтоолын биелэлтийг мөн тогтоолд заасан хугацаанд Улсын Их Хуралд танилцуулах үүрэгтэй гэж заасны дагуу тогтоолын төслийг санаачилсан.

Монгол Улсын тухайн жилийн төсвийн тухай хуулиар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг жил бүр батлан

хэрэгжүүлж ирсэн боловч сүүлийн жилүүдэд эдгээр төслүүдийн анх батлагдсан төсөвт өртөг нэмэгдэх, хэрэгжилтийн хугацаа сунжрах, гүйцэтгэл саатах, зарим тохиолдолд зогсох зэрэг асуудал тогтмол давтагдаж байна.

Тухайлбал, 2024 онд нийт 449 төсөл, арга хэмжээний төсөвт өртөг нь 1.6 их наяд төгрөгөөр нэмэгдэж, мөн тухайн жилийн нийт төсвийн хөрөнгө оруулалтын 43 хувийг эзэлсэн бол 2025 онд 142 төсөл, арга хэмжээний төсөвт өртөг нь 971.0 тэрбум төгрөгөөр, 2026 онд 136 төсөл, арга хэмжээний төсөвт өртөг 805.0 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

Мөн 2024-2026 оны төсөв болон төсвийн хүрээний давхардлыг арилган тооцоход нийт 522 төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртөг 1.9 их наяд төгрөгөөр өссөн нь улсын төсөвт ихээхэн дарамт учруулж байгаа.

Мөн тухайн бүс нутгийн иргэд төрийн үйлчилгээг цаг алдалгүй авах эрх нь хязгаарлагдаж байна гэж үзэж байгаа.

Энэ нь төсвийн сахилга бат, төлөвлөлтийн чанар хангалтгүй, хөрөнгө оруулалтын үр ашиг буурч байгааг, мөн шинэ төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх төсөв санхүүгийн боломж хязгаарлагдаж байгааг тус тус илэрхийлж байна.

Улсын Их Хурлын тогтоолын төслийн заалт тус бүрээр танилцуулбал 4 заалттай бөгөөд нэг заалт нь дотроо 5 заалттайгаар боловсруулагдсан байгаа.

- ➔ 1.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төсвийн хуульд тусгаж санхүүжүүлсэн хэдий ч анх батлагдсан төсөвт өртөг нь хүрэлцэхгүй болсон, хугацаандаа ашиглалтад орохгүй зогссон төсөл, арга хэмжээнүүдийн талаар судалж, ашиглалтад орохгүй зогссон шалтгаан, нийгэм, эдийн засагт үзүүлж буй сөрөг үр дагавар, улсын төсөвт үзүүлж буй ачаалал дарамт зэргийг тодорхой үзүүлэлт, аргачлалын дагуу төсөл, арга хэмжээ бүрээр тус бүр тооцож тайланг 2026 оны 07 сарын 01-ний дотор Улсын Их Хуралд танилцуулах.
- ➔ 2.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлсэн хэдий ч дуусгалгүй зогсоосон, цаашид улсын төсвийн хөрөнгөөр гүйцээн санхүүжүүлэх шаардлагагүй гэж дүгнэсэн төсөл, арга хэмжээг хувьчлах, дуудлага худалдаагаар түр хувийн хэвшилд шилжүүлэх санал дүгнэлтийг нэг бүрчлэн гаргаж, 2026 оны 07 сарын 01-ний дотор Улсын Их Хуралд танилцуулах.
- ➔ 3.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлж буй барилга байгууламж бүхий төсөл, арга хэмжээний хугацаандаа орохгүй саатаж буй, анх батлагдсан төсөвт өртөг нь өөрчлөгдөж байгаа шалтгааныг судалж, төсөвт дарамт үүсгэж байгаа шалтгааныг арилгах арга хэмжээ авах.

- ➔ 4.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санал авах, эрэмбэлэх, төлөвлөх, батлах үйл явцыг бодит цагийн байдлаар харах, ашиглах боломжоор хангах, мэдээллийг нэгтгэсэн систем дэх стандартчилах.
- ➔ 5.Улсын Их Хурлаар улсын жилийн төсөв хэлэлцэн батлах хугацаанд Төсвийн тухай хуулийн 29.4-д заасан систем дэх мэдээллийг Улсын Их Хурлын гишүүдэд бүхэлд нь харах боломжоор хангах.

2 дугаар заалт. Тухайн жилийн төсвийн тухай хуулиар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний санал авах, эрэмбэлэх, төсөл, арга хэмжээнд тавигдах шаардлагыг хянах хүрээнд хууль тогтоомжийг хэрэгжүүлэх зорилгоор баталсан нийтээр дагаж мөрдөх эрх зүйн актад дүн шинжилгээ хийх, хууль тогтоомжийн нийцлийг хангах, давхардлыг, хийдэл зөрчлийг арилгах чиглэлд зохион байгуулах арга хэмжээг авч тухай бүрд мэдээлж ажиллахыг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороонд даалгах.

Энэ тогтоолын 2 дахь заалтад заасан дүн шинжилгээ хийхэд шаардлагатай мэдээллээр хангаж туслалцаа үзүүлж ажиллахыг Монгол Улсын Засгийн газрын Ерөнхий сайд Н.Учралд даалгасан.

Энэ тогтоолыг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр тусгалаа.

Хуулийн дагуу 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдөр олон нийтээр нээлттэй хэлэлцүүлэхээр зохион байгуулсан, олон нийтийн санал авах зорилгоор d.parliament цахим сүлжээнд 2025 оны 12 сарын 23-ны өдөр байршуулсан Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 12 сарын 31-ний өдрийн 35 дугаар хуралдааны тэмдэглэлээр Засгийн газар зарчмын хувьд дэмжсэн байгаа.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Эрхэм гишүүд та бүхнийг тогтоолыг дэмжиж ажиллахыг хүсье.

Н.Наранбаатар: Б.Пунсалмаа гишүүнд баярлалаа. Танилцуулгатай холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгье.

Д.Батбаяр гишүүнээр тасаллаа. Н.Алтанхуяг гишүүн асуулт асууя.

Н.Алтанхуяг: Энэ зөв зүйтэй, хэрэгтэй тогтоолын төсөл орж ирж байна.

Надад нэг асуулт гээд байх юм алга, надад санал байна. Төсөвт өртөг нь хүрэлцэхгүй болсон гээд энэ 1 дүгээр зүйл дээр. Энэ чинь угаасаа л ийм болчихоод байгаа шүү дээ. Манай энэ төсөв, төсвийн хөрөнгө оруулалтын дампуураад байгаа шалтгаан бол он олон, он удаан жил үргэлжлээд байгаа гол шалтгаан бол олон жил олон жил дамнуулж хийдэг.

Ерөөсөө 100 объектыг 5, 6 жил барьсанд орвол 30 объектыг 2 жилийн дотор л барьдаг ийм л юм хиймээр байгаа юм. Б.Пунсалмаа гишүүн. Таны санаачилгыг би дэмжиж байгаа юм. Тэрийг цаашаагаа энэ хэлэлцэгдээд явахаар нэг засаж, засах юу байх вэ, нэмж оруулдаг арга юу байна?

Ер нь зүгээр манай Засгийн газрын үед энэ дээр зогсоогоод бариад юм хийсэн л дээ.

Тэгээд таны энэ 2 дугаар заалт дээр ийм байгаа. Төсөвт өртөг нь өөрчлөгдөж байгаа шалтгаан нь. Энэ чинь хугацаа нь хол болохоор л төсөвт өртөг нь шинэчлэгдээд л, "үгүй ээ 5 жилийн өмнө эхэлсэн" гээд л шинэчлэгддэг байхгүй юу.

Тэгээд энэ төсөвт өртгийг өөрчлөөд байдаг Барилгын хөгжлийн төв, төсөвчин гээд нэг нөхдүүд бий. Тэд нартай холбоотой жаахан заалт байхгүй л байна.

Тэгээд яах вэ Н.Учрал Ерөнхий сайдад нь өгөхөөр хийж болох юм болов уу?

Энэ 05 дугаар зүйл хэрэг байгаа юм уу? Энэ Улсын Их Хурал маань тогтоол гаргаж байж Засгийн газраасаа нэг тоо харах зөвшөөрөл авна гэдэг агуулгатай л юм яваад байна л даа.

Ер нь зүгээр хэрвээ байдаг юм бол төсөв хэлэлцэн батлах хугацаанд биш, Улсын Их Хурлын жилийн, ер нь бид ямар ч үед хардаг л баймаар байна шүү дээ.

Сангийн яамныхан хуураад байгаа. Юм асуухаар "та тэрнийг ороод харчих, тэр юман дээр байгаа" гэсэн чинь нарийн юм нь харагддаггүй юм.

Б.Пунсалмаа гишүүн тэрнийг олж мэдсэн л байна л даа.

Тийм учраас үүнийг байна шүү дээ, хэрвээ харах юм болбол, энд заалт байна гэх юм бол энэ бид үргэлж хардаг баймаар байна шүү дээ.

Улсын Их Хурал дээр нэг сайн юм бий болсон байна лээ. Манай Улсын Их Хурлын Тамгын газар хийсэн. "Хуулийн хувийн хэрэг" гэдэг юмыг бид Улсын Их Хурлын гишүүд тэрний хувийн хэргийг үзье гэвэл шууд онлайн хардаг болсон. Их сайн болсон. Түүн шиг Засгийн газраасаа нэг их тогтоол гаргаж гуйгаад байхдаа яадаг юм. Тэрийгээ Н.Учралд нь хэлээд л тэгээд л яана. 5 бол бараг илүүц байна гэж харж байна.

Дараа нь энэ 3 дугаар зүйл чинь ингэж байх юм. "Шинжилгээ хийхэд шаардлагатай мэдээллээр хангаж туслалцаа үзүүлж ажиллахыг Монгол Улсын Засгийн газар Н.Учралд даалгасугай." Энэ бараг илүүц биз дээ. Энэ угаасаа Засгийн газрыг энэ юмнуудаа хийгээд ороод ирээч ээ, ингээч ээ гэж байна.

Би энэ тогтоолын төсөл бол маш чухал тогтоолын төсөл байна. Үүнийг иймэрхүү тогтоол... /минут дуусав/

Н.Наранбаатар: 1 минут нэмж өгье. Н.Алтанхуяг гишүүнд.

Н.Алтанхуяг: Засгийн газар маань энэ дээр жаахан идэвх зүтгэлтэй ажиллаад, тэгээд он удаан жил, олон жил дамжиж баригддаг энэ асуудал, төсөвт өртөг нь өсдөг энэ асуудал, энэ нь цаанаа дандаа л авлига л явж байгаа шүү дээ.

Тийм учраас 2-оос 3 жилээс хэтрүүлэхгүйгээр барьдаг тийм юмыг л энэ тогтоол дотроо хэлэлцүүлгийн явцад жаахан нэмээд өгвөл болмоор байна.

Дахиад яах вэ, манай Их Хурлын гишүүд бид нарыг буруутгадаг шүү дээ. "Та нар л нэг баахан хэрэгтэй хэрэггүй объект, зурагтай зураггүй объект зүтгүүлсээр байгаад оруулаад" гээд. Та нарт би Сангийн сайд нарын аргыг хэлж өгье. Сангийн сайд бол Их Хурлын гишүүдээр төсөв батлуулахын тулд "тэгье тэгье наадхыг чинь тавья" гээд тавьдаг юм. Дараа нь та нарынхыг "зураггүй" гээд хасдаг юм. Эсвэл "тендерийг чинь зарласангүй" гээд хасдаг. Ингээд молигодүүлж дууссан байлгүй. Одоо иймэрхүү юмаар оролдохгүйгээр хэдүүлээ энэ улс орноо бодоод. Одоо энэ чинь бараг 50 хүн тойроггүй байгаа шүү дээ.

50 хүн тойроггүй байгаа гэдэг чинь маш их юм. Бид Монголын... /минут дуусав/

Н.Наранбаатар: Х.Булгантуяа гишүүн асуулт асууя.

Х.Булгантуяа: Би бол яах вэ, зарим зохицуулалтууд бол байгаа.

Тэгэхдээ Б.Пунсалмаа гишүүний хэлж байгаагаар тэгэхдээ арилахгүй байна уу гэвэл арилахгүй байна. Уг нь хуулийн зохицуулалт бий. Үүний тод жишээ бол сая 2026 оны төсвийг батлахад улаан ногоон лаазаар Улсын Их Хурал дээр 1.3 их наядын төсөвт өртөгтэй төсөл хөтөлбөр тавьсан. Үүний 300 гаруй тэрбумыг 2026 онд санхүүжүүлэхээр тавьсан.

Тухайн үед Үндэсний аудитын газраас бараг 400 орчим тэрбум төгрөг дээр нь "энэ бол хэрэгжүүлэх боломжгүй байна. Төсвийн тухай хуулийн нөгөө төсвийн бэлтгэлийг хангах ажлууд нь хийгдээгүй" гэсэн. Өөрөөр хэлбэл үүнийг төсвийн ерөнхийлөн захирагч, би сайд хүн байсан бол би бол айгаад тэрийг хэрэгжүүлж чадахгүй. Хэрвээ би тэрийг хэрэгжүүлэх юм бол би бараг хэрэгт орох байх дараа нь. Яагаад гэвэл аудитын газраас "болохгүй шүү" гэсэн юмыг санхүүжүүлэх болчихоод байгаа байхгүй юу.

Үүнээс үүдээд бид нарын аягүй сайн бодох ёстой юм нь хэд хэдэн юмнуудыг Улсын Их Хурал дээр хэрвээ тийм зарчмын зөрүүтэй санал гарвал яах юм?

Тэгвэл бүгд Улсын Их Хурал батлахгүй байна аа, батлах юм бол бараг яг үнэнийг хэлэхэд жинхэнэ нөгөө хууль зөрчсөн гээд ёстой жинхэнэ Үндсэн хуулийн цэцээс нь ч байдаг юм уу, акт гардаг юм уу, яадаг юм, тийм арга хэмжээ авахгүй бол Улсын Их Хурал дээр 1.3 их наяд нөгөө нэг тэтгэвэрийн чинь нэмэгдлийн хэмжээний мөнгийг аваачаад улс төрийн оноо цуглуулах гээд, Засгийн газраа авч үлдэх гээд тухайн үедээ баахан шинэ төсөл, хөтөлбөр тавьсан нь үнэн шүү дээ.

Хоёр дахь асуудал нь болохоороо бид жилийн төлөвлөгөө батлахдаа нэг жилийн төлөвлөгөөний хэлэлцүүлэх чуулганы хуралдааныг яг даргалж байсан. Тэгэхэд гишүүд маш их санал гаргаад ерөөсөө яаж ч бодсон түүнийг Улсын Их Хурлаар батлахад дараа жил Засгийн газар яаж ч барахааргүй, санхүүжүүлж чадахааргүй баахан юмнуудыг, мөрөөдлийн жагсаалтаа батлуулдаг. Тойрогтоо зам тавина, сургууль барина, Кембрижийн сургууль барина, эмнэлэг барина гээд. Тэгээд тэр нь "яах вэ ийшээ орвол төсөвт тавигдана" гэж боддог.

Тэгээд жилийн төлөвлөгөөнд орлоо гэдэг нь төсөв нь тавигдана гэсэн үг биш ээ.

Хэдэн юмнуудыг л хиймээр байгаа юм. Нэгдүгээрт, би Сангийн яамнаас асуумаар байна. Та бүхэн жишээлбэл яг 3 жилийн хугацаанд жишээлбэл хэрэгжүүлэх ёстой гээд төсвийг нь хувааж тавина гэвэл яг тавьж чадаж байгаа юу? Үүнийг бид Төсвийн тухай хууль дээр хийж өгсөн. Хэзээ хийсэн билээ. Яг тэгж тавьж чадаж байгаа юу? Нэгдүгээр асуудал.

Хоёрдугаар асуудал. Сая төсвийн үеэр болсон хэлэлцүүлэг дээр их аудитын хувьд асуудалтай шүү гэдэг энэ олон том хөрөнгө оруулалтуудыг, төсөл хөтөлбөрүүдийг тавихад Та бүхэн маань болно болохгүй гэдэг талаар Улсын Их Хурал дээр, Төсвийн байнгын хороон дээр ер нь хэлж байсан уу? Яагаад гэвэл дараа нь санхүүжүүлэх үүргийг та нар хүлээнэ шүү дээ. Сонгуулийн дараа ч та нар санхүүжүүлэх байх. Миний бодлоор.

Тэгэхээр энэ санхүүжүүлэх үүргийг татвар төлөгчдийн мөнгийг үүрч байгаа төрийн байгууллагын хувьд үүн дээр нь Та бүхэн маань хамгийн чухал зүйл нь тэр л дээ. Улс төрчдийн хэмжээ хязгааргүй улс төрийг төсвийнхөө... /минут дуусав/

Н.Наранбаатар: Сангийн яам, 6 номер хариулъя.

Ж.Дэлгэржаргал: Х.Булгантуяа гишүүний асуултад хариулъя. Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал.

Сүүлийн 2016-2025 онд бид 3 мянга гаруй бүтээн байгуулалтын төсөл хэрэгжүүлсэн байгаа.

Тэгээд нийт төслийн 43 хувь нь ямар нэгэн байдлаар өртөг нэмэгдэж байж ашиглалтад орсон.

2022 он болон 2023 он дээр бид төсвийн хууль дээр хөрөнгө оруулалттай холбоотой зохицуулалтуудыг, нэлээн шаардлагуудыг нь тавьж өгсөн. 3 жил багтаан дуусах ёстой.

Манай хийж байгаа судалгаагаар маш эртний зураг төсвөөр төлөвлөхөөр өртөг нь хүрэлцэхгүй байгаа асуудал байгаа учраас сүүлийн 2 жилийн зураг төсөлтэй байна гээд.

2023 оноос эхлээд бид зохицуулалтын бодлого буюу нэг жил нь шинэ хөрөнгө оруулалтаа тэвчдэг, нэг жил нь явж байгаа төслүүдээ үргэлжлүүлэх бодлого явсан.

2026 оны хувьд өргөн барьсан шинэ төслийн тоо гэхэд 149 төсөл маань батлагдахдаа 296 болж батлагдсан. 155-аар нэмэгдсэн. Эдгээр төслүүдийн өртөг бараг 2 их наядын өртөг байгаа.

Яг үүнтэй холбогдуулаад ерөнхийдөө өртөг нэмэгдэх асуудал, яаж төслүүдийг хугацаанд нь дуусгах вэ дээр Хэмнэлтийн хуулийн 5 сарын 31 явж байгаа.

Тэгэхээр аль болохоор бэлтгэл ажил хангасан, хэрэгжих боломжтой төслүүд нь гэрээгээ хийгдээд, амжаагүй бол хэмнэлтэд ороод дараа жилийн төлөвлөлтөө сайжруулж явах асуудал байгаа.

Нэгэнт яг Улсын Их Хурлаар батлагдсан хөрөнгө оруулалт хууль учраас бид хуулийн хүрээнд худалдан авах ажиллагаа, гэрээ нь хийгдээд явах, санхүүжүүлээд явах үүрэг хүлээдэг. Яг энэ нэмэлт санхүүжилт дээр үүсээд байгаа асуудал дээр тусгайлсан хуулиар зохицуулсан мэргэжлийн байгууллагууд зураг төсөв дээр магадлал, эксперт хийж байгаа. Энэ дээр нь бид давхар сүүлийн 3 жил Улсын Их Хурлын тогтоол гаргаад Үндэсний аудитын газар дахиад хянаж магадалсны дараа төсвийн төсөлд тусгаад явж байгаа.

Н.Наранбаатар: Х.Булгантуяа гишүүн тодруулъя.

Х.Булгантуяа: Үүнтэй холбоотой нэг хэд хэдэн асуудал байгаа юм аа, Төсвийн байнгын хорооны дарга аа.

“Барилгын хөгжлийн төв”, “Зам, тээврийн хөгжлийн төв” гэж бас байдаг. Тийм ээ. Тэгээд барилгын, замын төсөвт өртгүүдийн нэмэгдэл төсөвт өртгийг, дээрээс нь нэмээд хэрвээ нэмэгдэх шаардлагатай бол түүнийг нь хянадаг газар гэж би ойлгосон.

Үүний дараагаар бид төсвийг дагаж тогтоол ороод Үндэсний аудитын газар тэрүүн дээр нь давхар хяналт тавина гэж хийж өгсөн. Тэгсэн Үндэсний аудитын тухай хууль дээр ийм зохицуулалт байхгүй юм байна. Төсвийн байнгын хорооны дарга аа.

Тэгэхээр одоо Үндэсний аудитын газар юу гэж хэлээд байна вэ гэхээр "Улсын Их Хурлын тогтоолоор бид нарт хэдэн их наядын төсөвт өртгийг нь нэмж хянах манай хуульд байхгүй, манай чиг үүрэгт байхгүй ийм даалгаврыг нэмж өгөөд байна. Хуульд байхгүй байна. Эсвэл үүнийг нэмж бид нарт тусгаж өгөөч ээ."

Тэгээд яг үнэнийг хэлэхэд Барилгын хөгжлийн төв, Зам, тээврийн хөгжлийн төв нь хянаад "өө нээрээ энэ нэмэгдэх ёстой юм байна аа" гээд оруулж ирж байгаа юмыг аудитын газар "бид нарийн мэргэжлийн барилгын инженер, замын инженер байхгүй болохоор бид үүнийг." /минут дуусав/

Н.Наранбаатар: Тийм. Асуулт уу, үг хэлэв үү?

Энэ жилийн аудитын сэдэвт ороод батлагдаад явж байгаа. Да.Цогтбаатар гишүүн асуулт асууна.

Да.Цогтбаатар: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе.

Ямар ч байсан улаан намын цагаан байрныхны хулгайг бага гэхгүй илрүүлж, бас нэг ажил хэрэгч хандаж, зөв тогтоолын төсөл оруулж ирж байгаа Б.Пунсалмаа гишүүнд талархал илэрхийлье.

Энэ яагаад зөвхөн улаан намын цагаан байрны хулгайч нар гээд байна гэхээр би зүгээр гуравхан жишээ хэлье. Энд нийтдээ 522 төслийн 2 их наядын асуудал яригдаж байгаа. Зөвхөн зөрүүнд нь.

2022 онд Баянхонгор аймагт Баацагаан суманд орон сууцны төслийн дэд бүтэц гээд 2.3 тэрбумаар эхэлсэн ажил одоо энэ дээр явж байгаа нь 9.6 тэрбум буюу 7.3 тэрбумаар нэмээд хулгай хийж байгаа юм.

Дахиад нэг жишээ, Өвөрхангай аймгийн Арвайхээр хотод бас л барилгын дэд бүтэц, хуучин орон сууцны дэд бүтцийн төсөл гээд тэрбумаар тендер зарлаад нөгөөдөх нь явсаар байгаад 5.2 тэрбум буюу 4.2 тэрбумын дахиад хулгай.

Дахиад 2022 оны жишээ. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын харьяа байгууллагуудын барилгын их засвар гээд 500 саяар эхэлсэн ажил чинь 6.5 тэрбум буюу дахиад 6 тэрбумаар нэмэгдээд, дандаа 2022 онд хулгай.

Зүгээр л гурван жишээ авахад л ийм байгаа байхгүй юу. Энэ бол дандаа хулгай. Тэгээд үүнийг чинь хулгай гэж үзэхгүй үү, юу гэж үзэх вэ. Одоо жишээлэхэд дахиад Эрүүл мэндийн сайд нарын дундын зодооноос болж гэх юм уу, Хавдрын эмнэлэг, яг Хавдрын эмнэлгийнхээ дэргэд хавдрын эмнэлэг барьсан.

Тэгээд энэ хавдрын эмнэлгийг улсын төсөвт авахад, жишээлэхэд өнөөдрийн байгаа үнээр нь, шүүхийн шийдвэр дээр байгаа үнээр нь авахад 70, 80 тэрбум төгрөгийн л асуудал яригдана. Төсвийн өртөг нэмэгдэхгүй. Хавдрын эмнэлгийнхээ дэргэд хавдрын өвчнөөр өвчлөөд байгаа хүмүүсийнхээ яг дэд бүтцийг нь шийдсэн 2 эмнэлэг нь нэг доороо. Тэгээд төсөвт өртөг дахиж өсөхгүй.

Тэгээд энэ чинь Хөгжлийн банкныхаа өрөнд ч хэрэгтэй, эмнэлэгтээ ч хэрэгтэй, иргэддээ ч хэрэгтэй энэ мэт зөв асуудал руугаа орж чадахгүй дахиад энэ хавдрын эмнэлэг яаж байна гэхээр Сонгинохайрхан дүүрэгт очоод 600 ортой 570.0 тэрбум төсөвт өртөгтэй шинэ эмнэлэг эхэлж байгаа юм. Одоо жишээлэхэд Б.Пунсалмаа гишүүн үүнийг төсөвлөж орж ирээгүй бол дахиад энэ 570 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй барилга хэд болж өсэхийг хэн ч мэдэхгүй. Хэн ч таахгүй.

Тэгэхээр энэ мэт хулгайгаа байран дээр нь зогсоох ёстой учраас энэ тогтоолын төслийг дэмжиж байна. Тийм. Ээ чинь нийтдээ 522 төсөлд анхнаасаа 3 их наяд байсан юман дээр хулгай нь 2 их наяд, зөвхөн нөгөө нэмэгдэж байгаа өртөг нь. Энэ үеэс хойш ковид гэж байгаагүй. Янз бүрийн хямрал болоогүй. Яг ингээд л асуудал хэвээрээ явж байхад л хулгай ингэж гардгийн жишээ нь энэ.

Тэгэхээр одоо би Б.Пунсалмаа гишүүнээс, эсвэл энэ ажлын хэсгээс асуух гээд байгаа нь одоо энэ хулгай гарсан байгаа төслүүдийнхээ эцсийн өртгийг яаж тогтоох юм л гэдгийг асуух гэсэн юм. Эцсийн өртгийг нь.

Н.Наранбаатар: Асуулт асуусан уу? Б.Пунсалмаа гишүүн хариулъя.

Б.Пунсалмаа: 2016-2025 оны байдлаар сүүлийн 9, 10 жилд 2874 төсөл, арга хэмжээг шилжих хөрөнгө оруулалтаар санхүүжүүлсэн байгаа юм. Эдгээр төслүүдээс нийтдээ 500-аад төсөл нь нэмэгдэж орж ирсэн. Нэмэгдсэн дүн нь 1.9 их наядар нэмэгдэж байсан.

Тэгэхээр энэ бол маш их хэмжээний нэмэгдэл гээд яриад байгаа. Хэрвээ нэмэгдэл үүсдэггүй байсан бол энэ дүнгээр цахилгаан станц бид барих хангалттай боломж байсан. Нөгөө талаараа энэ нэмэгдэлтэй бид хамаг төсөв бүгдийг нь тавьж зориулаад шинэ төсөл, арга хэмжээ орж ирэх боломжгүй болчихоод байгаа юм.

Тэгээд шинээр орж ирж байгаа төслүүд нь сүүлийн 4 жил 2874 хуучин төсөл орж ирчхээд шинэ төсөл, арга хэмжээнд дөнгөж 300-хан шинэ төсөл, арга хэмжээ.

Тэгэхээр цаашдаа бид шинэ төсөл, арга хэмжээ буюу нэн хэрэгцээтэй, нийгэм, эдийн засагт үр дүнтэй төслүүдээ оруулж ирэхийн тулд тэр өмнө нь нэмэгдэж байгаа төсөл, арга хэмжээнүүдийнхээ төсөл нэмэгдээд байгаа шалтгааныг нь олж тодруулах, зарим нийгэм, эдийн засагт нэн үр ашиггүй гэж үзсэн төсөл, арга хэмжээнүүдийг цаашдаа Засгийн газрын зүгээс гүйцээн санхүүжүүлэхгүй байх. Үүнийг менежментийн өөр хэлбэрт шилжүүлж, эргүүлж

төлсөн татвар төлөгчдийн тэр оруулсан тэр хөрөнгийг нь эргүүлээд улсын төсөвт оруулаад үр дүнтэй төсвүүдэд зориулах зорилготойгоор энэ тогтоолын төслийг гаргаж ажиллаж байгаа юм.

Таны хэлж байгаатай санал нэг байна. Бас энэ төсөвт өртөг нэмэгдээд байгаа шалтгаан нь хэрэгжүүлэх явцдаа зарим жил дамнасан төслүүдийг дунд нь 1, 2, 3 жил гацааснаас болж маш олон жил өнждөг. Түүнээс болоод энэ төслүүд инфляцад маш ихээр нэмэгдээд тэгээд төсөвт өртөг нь нэмэгдэх үндсэн шалтгаан болоод байдаг юм гэж гаргаж ирж байгаа.

Сүүлийн үеийн Төсвийн тухай хууль дээр Б.Тэмүүлэн гишүүний санаачилсан хуулийн өөрчлөлтөөр шинээр орж ирж байгаа төслүүдийг 3 жилийн дотор гүйцээн санхүүжүүлж дуусгана гэсэн ийм тогтоолын төсөл орж ирсэн. Ийм хуулийн өөрчлөлт орж ирсэн. Энэ бол маш зөв буюу энэ заалтаараа бид шинэ төслүүдээ хэрэгжүүлээд явахад 3 жил дотроо дуусгаад явах боломж үүсэж байгаа юм.

Н.Наранбаатар: Д.Батбаяр гишүүн асуулт асууна.

Д.Батбаяр: Ажлын хэсгийнхний энэ өдрийн мэндийг хүргэе.

Тэгээд энэ тогтоолын төсөл маш чухал ач холбогдолтой төсөл байгаа юм. 19 гишүүн ирцдээ орсноос ихэнх нь гараад явсан байгаад байна. Манай эрх барьж байгаа намынхан маань бүгд ихэнх нь гараад явсан байдаг.

Санал хураавал ер нь унах гээд байна л даа. Үүнийгээ бодох хэрэгтэй байх.

Яагаад эхнээс нь дэмжлээд явсан бэ гэхээр өнгөрсөн жил хагасын хугацаанд би Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны дарга хийж байсан.

Тэгээд энэ хийж байх хугацаандаа 2016-2024 оны хооронд төсөвт суугдсан, улсын төсвөөр хэрэгжиж эхэлсэн, гацсан, ямар нэгэн байдлаар алдаатай байдлаар хүлээж авсан ийм төслүүдийг судлах, дүн шинжилгээ хийх судалгаа хийлгэсэн юм. Төсвийн зарлагын хяналтын дэд хороон дээр.

Тэгээд таны яг энд сая уншдаг тогтоолын төслийн 1.1 дээр байгаа бүх төслүүд дээр дүн шинжилгээ хийе гэдэг тэр заалт бол үндсэндээ нийгмийн чиглэлээр нь буюу соёлын, сургуулийн, боловсролын, эрүүл мэндийн чиглэлээр нь шинжилгээнүүдийг нь хийсэн юм.

Тэгээд энэ нь бол маш хангалтгүй гарсан. Маш их хэмжээний төслүүд гацсан, зогссон байдалтай байгаа. Үүний бас нэг учир шалтгаан нь юу байдаг вэ гэхээр зөвхөн санхүүгээсээ гадна зураг төсөлтэй холбоотой байдаг. Аливаа төслүүдийг улсын төсөвт суулгахдаа зураг төслийг нь дутуу буюу дулимаг хийснээсээ болоод, буруу хийснээсээ болоод гацдаг. Нэмж зураг хийх шаардлага

үүсдэг, энэнээсээ болоод ахиад төсөв дээр хүлээгддэг, яаман дээрээ хүлээгддэг асуудлууд гардаг.

Энэ бол зөвхөн Сангийн яаман дээр ч байдаг юм уу, Хөрөнгө оруулалтын газар дээр нь бүгд л яг хуулийнх нь дагуу ажлаа хийгээд байгаа юм л даа. Яадаг вэ гэхээр орон нутаг дээрээ асуудлууд байдаг. Зураг зурахдаа асуудлууд үүсдэг гээд янз янзын асуудлууд байдаг.

Зөвхөн Сангийн яамтай нь, төсөвтэй нь холбож ярих нь учир дутагдалтай.

Байнгын хороон дээр сууж байгаа бүх саналын эрхтэй гишүүдийг энэ тогтоолын төслийг бүгдийг нь дэмжээд өгөөч ээ. Тэгээд энэ тогтоолын төслийг нь явуулаад дахиад хяналт шалгалтыг нь хийгээд, чиглэлийг нь өгөөд явах нь зүйтэй гэсэн саналтай байна. Санал байлаа.

Н.Наранбаатар: Г.Ганбаатар гишүүн асуулт асууна.

Г.Ганбаатар: Нөгөө "загатнасан газар маажна" гээд нэг үг байдаг. Тийм ээ. Түүн шиг төсвийн сахилга батыг сайжруулахад их чухал тогтоолын төсөл байгаа юм. Энэ төслийн хувьд.

Дээрээс нь Төсвийн байнгын хорооны гишүүний хувьд бид бүхэн ч гэсэн яг энэ оруулж ирж байгаа тогтоолын төсөл дээр их анхааралтай ажиллах юмнууд байгаа.

Зүгээр яах вэ, энэ мэдээж Улсын Их Хурлын чуулганаар ороод батлагдах байх. Өнөөдөр 19-өөс ирц 13 байна. Бодвол манай Төсвийн байнгын хорооныхон төсвийнхөө сахилга батыг сайжруулах чухал тогтоолын төслийг дэмжих байх гэж найдаж байгаагаа илэрхийлье.

Ер нь санал хэлж байгаа юм. Би үүнийг цаашдаа чуулган дээр асуух юм шүү. Барилга, хот байгуулалт, Сангийн яамныхан байж байх шиг байна.

Төсвийг ер нь хоёр янзаар л хулгайлаад байх шиг байгаа юм. Миний бодлоор.

Нэгдүгээрт, ковидын үед гарсан Улсын Их Хурлын тогтоол, Засгийн газрын шийдвэртэйгээр холбоотойгоор магадлан хийлгэдэг болсон. Магадлангийн мафи гэдэг юм үүссэн. Тогтоолын төсөл дээрээ сайн анхаарах хэрэгтэй.

Барилгын хөгжлийн төвийн дарга байж байх шиг байна. Тийм ээ. Барилгын хөгжлийн төв, аудит нийлж байгаад төсөв тавиулсан улс төрч гурав нийлж байгаад үндсэндээ төсөвт өртгийг яаж өсгөж болдгийг өчигдөр уржигдар Ардчилсан намын бүлэг дээр Боловсролын сайд ярьж байгаа байхгүй юу. 4 тэрбумаар эхэлсэн боловсролын салбарын нэг төсөл 40 тэрбум хүрсэн тухай. Өөрөөр хэлбэл 10 дахин өссөн гэсэн үг үү. Тийм ээ. Гэтэл таны энэ дотор чинь

бүр 1200 дахин өссөн тухай төсөл 4 арга хэмжээ байна, 600 хүртэл өссөн 14 төсөл, арга хэмжээ.

Тэгэхээр энэ асуудал гол тогтоолын төсөлд орох ёстой. Өөрөөр хэлбэл тэр магадлангийн мафи гэдэг нэг асуудал үүсээд байгаа.

Хоёрдугаарт нь, манай Н.Алтанхуяг даргын яриад байгаа. Авлига шингэсэн төсөв гэж. Энэ бол яг төсөвчин, төсөв хийдэг компани, улс төрчид нь нийлж байгаад авлига шингээсэн төсөв хийгээд байна. Үндсэндээ яг манай тойрог дээр болсон явдал шүү. Нэг газар нь нэг цаг хугацаанд нэг доор шахуу төсөвт өртөг нэг нь 5 тэрбумаар байж байхад нөгөөдөх нь 12 тэрбумаар байгаа байхгүй юу. Яг адилхан барилга, яг адилхан үзүүлэлттэй.

Тэгэхээр яагаад төсөвт өртгийн зөрүү өндөр гараад байна вэ гэдэг асуудал байгаа. Бас сунжирсан асуудал байгаа. Тийм ээ. 4 тэрбумаар 40 тэрбумаар дуусгаж байна гэдэг бол иймэрхүү хэт их өндөр төсөвтэй байгаа учраас өнөөдөр манай Монгол Улсын хөрөнгө оруулалтад зай байхгүй боллоо. Бид үндсэндээ улсын төсөв гэдэг зүйл бол уг нь төсвийн бодлогоор энэ чинь эдийн засгаа дэмжих гэж байгаа хэлбэр шүү дээ. Гэтэл нөгөөдөх нь эргээд эдийн засгаа боомилдог хэлбэр болоод байгаа.

Тэгээд энэ чиглэл рүү их анхаарах хэрэгтэй. Чуулган дээр би яг Барилгын хөгжлийн төвөөс өнгөрсөн хугацаанд сүүлийн хэдэн жилийн бүх тоонуудыг асууна шүү. Энэ чиглэлээр бэлдээрэй. Сангийн яам, Барилгын хөгжлийн төв бэлдээрэй. Магадгүй аудит тэр үед орж ирж магадгүй. Тэгвэл дэлгэрэнгүй асууна шүү.

Тэгээд дэмжиж байгаа гэдгийгээ хэлье. Энэ тогтоолын төслийг.

Н.Наранбаатар: Гишүүд асуулт асууж дууслаа. Одоо үг хэлэх гишүүд нэрсээ өгье. Алга байна. /алх цохив/

Гишүүд санал хураалтад бэлтгээрэй.

“Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

73.7 хувиар дэмжигдлээ.

“Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлж дууслаа. /алх цохив/

Тогтоолын төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар танилцуулна.

Төсвийн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье. Баярлалаа.

Хуралдаан 1 цаг 31 минут үргэлжилж, 16 цаг 23 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД